



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, АЙМАГ,
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА НАРТ

2023.03.09 № 1а/986
танай -ны № -т

Чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Өргөө” амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, санхүүжилт, чанар, хүртээмж, үр дүнгийн байдлыг шалгаж Эрүүл мэндийн яаманд зөвлөмж ирүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарт зөрчил гарах эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд байгууллага бүр дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахыг даалгаж байна. Үүнд:

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг дэмжих чиглэлээр:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд үүсээд байгаа өглөг, авлагын байдалд дүгнэлт хийж барагдуулах арга замыг тодорхойлох, Эрүүл мэндийн даатгалын санд учирч болох эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах;
2. Гүйцэтгэлийн санхүүжилтээр нэмэлтээр орж ирсэн орлогыг эхний ээлжинд үйлчлүүлэгчдэд хүргэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулах чиглэл баримтлах;
3. Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн хуваарилалт, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн хяналт, тайлагналтыг сайжруулах;
4. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хяналтын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын сантай холбогдсон харилцаанд даатгуулагч хяналт тавих тогтолцоог сайжруулах.

Эмийн хяналт, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд анхаарах;
2. Нэн шаардлагатай, өнчин, өндөр үнэтэй болон хадгалалт, тээвэрлэлтийн онцгой горим шаарддаг эмийн тасалдал үүсгэхгүй байх;
3. Эмчлүүлэгчийн ар гэрээс эм, эмнэлгийн хэрэгсэл авчуулахгүй байх, эмнэлэгт тасалдал үүсгэхгүй, нөөц бүрдүүлэх арга хэмжээ авах.

Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр:

1. Эрүүл мэндийн байгууллагууд орон тооны хэтрэлттэй, дутагдалтай, зарим албан тушаал (сувилагч)-ын шилжилт хөдөлгөөн ихтэй, хүний нөөцийн дутагдалд дүгнэлт хийж, хүний нөөцийг төлөвлөх, сонгон шалгаруулах, ажил, албан тушаалуудын томилгоог хуульд нийцүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, эрүүл мэндийн салбарын (байгууллагын) хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр цогц арга хэмжээ авч ажиллах;

2. "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг нийт ажилтан, ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх, Хөдөлмөрлөх эрхийн маргаан таслах комиссыг байгуулах;

3. Хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, ҮЭ-ийн хороотой хамтран ажиллах, гишүүнчлэлийн асуудлыг ил тод, нийт ажилтны хурлаар сонгож шийдэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах, Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах;

4. Албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хавсралтын дагуу албан тушаал бүрээр баталж, мөрдүүлэх;

5. 24/24 цагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хоногт 12 цагаас, 7 хоногт 56 цагаас илүү ажиллуулахыг зогсоох, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалинг хууль тогтоомжийн дагуу олгох, улирлын урамшууллыг олгох шалгуурыг шинэчлэх;

6. Ажлын байрны дарамт, ялгavarлан гадуурхалтыг таслан зогсоох, ажилтнуудын харьцаа, хандлагыг сайжруулах, байгууллага дотор эерэг орчин бүрдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг сайжруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

7. Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, цалин хөлсний бодлогыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах арга хэмжээ авах, ажилтнуудын санал, сэтгэгдлийг нээлттэй авч байх, сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэж, тодорхой ажлуудыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах.

Байгууллагын дотоод хяналт, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр:

1. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан нийтлэг журмыг үндэслэн өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлоог тохирсон "Дотоод хяналтын ажиллах журам"-ыг батлуулж, дотоод хяналтыг тогтмолжуулах;

2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж хэвших, байгууллагын цахим хуудсанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг нийтэд ил тод мэдээлж байх;

3. Засгийн газрын 2020 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол Улсын стандарт (MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021)-ыг мөрдлөг болгох, мөрдөлтийг сайжруулах;

4. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг хэрэгжүүлж, хувийн хэрэг байх үндсэн баримт бичгийн бүрдэлийг хангах, хувийн хэргийн баяжилтыг цаг тухай бүр хийх;

5. Байгууллагын бичиг хэргийн эргэлтийн хяналтыг сайжруулах, байгууллагын хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэг программ ашиглах;

6. Архивыг стандартын шаардлагад нийцүүлж, хадгаламжийн нэгжийг устгах, ашиглах боломжгүй болох эрсдэлээс хамгаалах.



С.ЧИНЗОРИГ